



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 62

Даланзадгад сум

“Өсөлтийг өрх бүрд” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. “Өсөлтийг өрх бүрд” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр баталж, арга хэмжээний зардлыг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д даалгасугай.
3. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, хөтөлбөрийн тайланг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАДРАА

462210102

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний
өдрийн 62 дугаар тогтоолын хавсралт

“ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД” ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, шаардлага

Өмнөговь аймаг нь 2020 оны байдлаар 21989 өрхийн 71493 хүн амтай ба үүнээс 28804 хүний ажиллах хүчний нөөцтэй, хөдөлмөрийн насны нийт хүн амын 62,3 хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байна.

Нийт 26471 хүн ажил хөдөлмөр эрхэлж байгаагаас хөдөө аж ахуйд 9805, уул уурхай, олборлолт 4260, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаанд 2171, жижиглэнгийн худалдаанд 1520 хүн тус тус багтаж байна. Ажилгүйдлийн түвшин 8,1 хувь байгаа нь өмнөх оноос 2,1 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй, ажилгүй болон боломжит ажиллах хүчний нэгдсэн хувь 10,3 хувь байна.¹

2020 оны 12 сарын байдлаар ажил хайгчаар бүртгүүлсэн 496 иргэдийг боловсролын түвшингээр авч үзвэл боловсролгүй 6, бага болон суурь боловсролтой 39, бүрэн дунд боловсролтой 273, техникийн болон мэргэжлийн боловсролтой 37, тусгай мэргэжлийн дунд 27, дээд боловсролтой 114 хүн бүртгүүлсэн байна. Дээрх үзүүлэлтээс харахад ажил хайгчаар бүртгүүлсэн иргэдийн дийлэнх буюу 55 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байна. Иймд эдгээр иргэдийг мэргэшүүлэх сургалтад хамруулж ажилд зуучлах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны байдлаар 168 жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийн судалгааг авч нэгтгээд байна. Үүнээс 68 нь буюу 40.5% нь иргэн хувиараа болон өрхийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч үлдсэн 100 буюу 59.5% нь аж ахуй нэгж үйл ажиллагаагаа явуулж нийт жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний 12 салбарын 616 ажиллагсад байна. Аймгийн төв болон сумын төвийн нэг өрхийн дундаж орлого 2020 оны байдлаар 1,313,481 төгрөг байна. Үүнээс цалин хөлсний орлого 630,250 төгрөг байна.

Өмнөговь аймгийн банкны нэгжийн нийт зээлийн багц 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 254.6 тэрбум төгрөг, үүний 6.6 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад чанаргүй зээлийн хэмжээ 10.5 тэрбум төгрөг буюу 4.2 нэгж хувиар өссөн байна.²

Ковид-19 цар тахлын дэгдэлттэй холбогдуулан хорио цээрийн дэглэм тогтоож үйлдвэрлэл, үйлчилгээний салбар тодорхой хугацаанд зогсонги байдалд орсон. Энэ нь эдийн засагт нөлөөлж Улсын нэгдсэн төсвийн орлого, тусламж 13,6 хувиар буурч, уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл 6,1 хувиар, экспорт 0,6%, импорт 13,6% хувиар тус тус буурч нийгмийн халамжийн тэтгэмж 2,4 дахин өссөн үзүүлэлттэй байна.³

Цар тахалтай холбоотойгоор аялал жуулчлалын салбар улсын хэмжээнд уналтад орж 2019 онд 577,300 жуулчин манай улсын хилээр нэвтэрсэн бол 2020 онд 58,859 болж буурсан байна.⁴ Гэвч нөхцөл байдалтайгаар холбогдуулан дотоодын аялал жуулчлал хөгжих нөхцөл боломж үүссэн.

¹ Статистикийн үндэсний хороо

² Монгол банкны Өмнөговь аймаг дахь салбар

³ Статистикийн үндэсний хороо

⁴ Статистикийн үндэсний хороо

Иймд салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж уул, уурхай болон хөдөө аж ахуйн салбараас гадна аялал жуулчлал, жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл, бичил уурхай зэрэг бусад салбаруудын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж иргэдийн тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Хөдөө аж ахуй, уул уурхай, төмөр зам зэрэг стратегийн ач холбогдол бүхий салбаруудыг түшиглэн ажлын байрыг нэмэгдүүлж, жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, хоршоо, нөхөрлөлийг бодлогоор дэмжиж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлын түвшинг бууруулна.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

- 3.1 Өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 3.2 Аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбар болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 3.3 Уул уурхай болон эдийн засгийн тэргүүлэх салбаруудын дэмжлэгтэйгээр ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 3.4 Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.
- 3.5 Зорилтот бүлгийн өрх, иргэдийн оролцоо, хөгжил, нийгмийн хамгааллыг бодлогоор дэмжинэ.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, уялдаа

- 4.1. Хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.
- 4.2. Дараах хөтөлбөрүүдтэй уялдаж хэрэгжүүлнэ.

- 4.2.1. “Чинээлэг малчин” хөтөлбөр
- 4.2.2. “Нутгийн үйлдвэрлэгч” хөтөлбөр
- 4.2.3. “Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая” хөтөлбөр
- 4.2.4. “Залуус” хөтөлбөр
- 4.2.5. “Цэгцтэй гэр хороолол” хөтөлбөр
- 4.2.6. “Түрээсийн орон сууц” хөтөлбөр
- 4.2.7. “Шинэ Мянганы Айл” орон сууцны хөтөлбөр

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1 Өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.

5.1.1 Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, хүнсний ногоог борлуулах “Өмнөговьд үйлдвэрлэв”, “Өмнөговьд тарьж ургуулав” борлуулалтын цэгийг Өмнөговь, Улаанбаатар хотод байгуулах;

5.1.2 Орон нутгийн өрхийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа боодлыг сайжруулах замаар борлуулалтыг нэмэгдүүлэхэд;

5.1.3 Уул, уурхай болон томоохон аж ахуйн нэгжүүдэд иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэлт хийхэд холбон зуучлах;

5.1.4 Хүлэмжийн аж ахуй, газар тариалан эрхлэгчдийг бодлогоор дэмжиж өрхийн орлогыг нэмэгдүүлэх;

5.1.5 Өрхийн үйлдвэрлэгчдийн дунд “Шилдэг үйлдвэрлэгч өрх” уралдааныг зохион байгуулж иргэдийн бүтээгдэхүүнийг сайжруулж, олон нийтэд сурталчлан таниулах;

5.1.6 Өрхийн үйлдвэрлэл эрхлэх боломжтой иргэдийн дунд төслийн уралдаан зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх;

5.2 Аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбар болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих;

5.2.1. Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгож, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бүтээлч байдлыг нэмэгдүүлэх;

5.2.2. Аялал жуулчлалын дэд бүтэц, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, тухайн бүс, орон нутгийн байгаль, нийгэм, эдийн засгийн онцлог, орон нутгийн иргэдэд түшиглэсэн соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх;

5.2.3 Малчид, хөдөөгийн ядуу өрхийн үйлдвэрлэл эрхлэх ур чадварыг дээшлүүлэх, ажлын байр, иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх;

5.2.4 Хоршоо, нөхөрлөлд гишүүнээр элсэн ажиллах хүсэлтэй ажилгүй, ядуу өрх, иргэдийн саналыг нэгтгэн бүртгэж, зуучлах үйл ажиллагааг зохион байгуулах;

5.2.5 Малчдын орлогыг улирлын нөлөөнөөс хамаарал багатай байлгах хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

5.2.6 Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5.2.7 Залуучууд, гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан технологи, инновацын төв байгуулж гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулна;

5.3 Уул уурхай болон эдийн засгийн тэргүүлэх салбаруудын дэмжлэгтэйгээр ажлын байрыг нэмэгдүүлнэ.;

5.3.1 Уул уурхай, төмөр замын бүтээн байгуулалт болон томоохон мега төслүүдэд ажиллах боловсон хүчнийг орон нутгаас хангахыг бодлогоор дэмжих;

5.3.2 Төмөр замд ажиллах боловсон хүчнийг орон нутагт бэлтгэх, мэргэшүүлэх сургалтад хамруулж ажлын байранд зуучлах;

5.3.3 Уул уурхай, томоохон үйлдвэр, дэд бүтцийн төслийг хэрэгжүүлэх явцад шаардлагатай бараа бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийг орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5.3.4 Уул уурхайн нөхөн сэргээлт, байгаль хамгааллын ажилд орон нутгийн иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгжийг оролцуулж, ажлын байрыг нэмэгдүүлэх;

5.3.5 Нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгжид орон нутгийн түгээмэл тархацтай ашигт малтмал, байгалийн дагалдах түүхий эдийг түр ашиглах эрхийг олгох;

5.4 Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.

5.4.1 Өрхийн аж ахуй, нөхөрлөл, хоршоо, үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дэмжих;

5.4.2 Төрийн үйлчилгээний зарим ажлыг орон нутгийн аж ахуйн нэгж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлэн, дэмжиж ажиллах;

5.3.3 Нийгмийн хариуцлага өндөр, шилдэг төрийн болон хувийн байгууллага, аж ахуйн нэгжийг олон нийтэд сурталчлан алдаршуулах;

5.3.4 Гэр хорооллын болон ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн орон сууцны хороолол болгон хөгжүүлэх үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

5.5 Зорилтот бүлгийн иргэдийн оролцоо, хөгжил, нийгмийн хамгааллыг бодлогоор дэмжинэ.

5.5.1 Зорилтот бүлгийн өрхийн багаас доош боловсролтой, ажил эрхлээгүй өрхийн тэргүүлэгч, насанд хүрсэн гишүүдийг Политехникийн коллежид мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг ахиулах сургалтад хамруулах;

5.5.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд зуучлах, ажлын байранд шаардлагатай сургалт, мэдээлэл олгох төвийг байгуулах;

5.5.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд зуучилсан аж ахуйн нэгж, байгууллагыг олон нийтэд сурталчлах, алдаршуулах;

5.5.4 Зорилтот бүлгийн иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах;

5.5.5 Өрх толгойлсон эцэг, эхчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хариуцагч байгууллага
				2021	2024	
1	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	хувь	62,3	64,5	68	АЗДТГ, ХХҮГ,ХХААГ, Сумдын ЗДТГ
2	Ядуурлын хамралтын хүрээ	Хувь	11,8 /2018/	10	8	АЗДТГ, ХХҮГ,ХХААГ, Сумдын ЗДТГ
3	Ажиллах хүчний оролцооны түвшин	хувь	67,8	69	75	АЗДТГ, ХХҮГ, ХХААГ, Сумдын ЗДТГ

4	Шинээр бий болсон ажлын байрны тоо	тоо	1292	1000	5000	АЗДТГ, ХХҮГ
5	Ажилгүйдлийн түвшин	хувь	8,1	7,5	5,0	АЗДТГ, ХХҮГ, ХХААГ, Сумдын ЗДТГ
6	Орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо	Иргэн	68	100	350	ХХААГ, ХХҮГ
		ААН	100	115	150	
7	Амьдрах орчин нөхцөл нь сайжирсан өрхийн тоо	тоо	90	150	750	ХХҮГ, ГБХЗХГ
8	Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо	тоо	188	200	1500	АЗДТГ, ХХҮГ
9	“Өмнөговьд үйлдвэрлэв” худалдааны цэг байгуулах	Тоо	1	2	3	АЗДТГ, ХХААГ
10	Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн тоо	Тоо	463	1000	5000	ХХААГ
11	Нэг өрхийн дундаж цалин хөлсний орлого /нэг сард/	Өссөн хувь	630,250 /төгрөг/	15%	60%	АЗДТГ, ХХҮГ, ХХААГ

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 7.1.1. улсын болон орон нутгийн төсөв
- 7.1.2. төсөл хөтөлбөр, хандив тусламж
- 7.1.3. бусад эх үүсвэр

Найм. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг сумдын Засаг даргын тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж, ахуйн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Политехникийн коллеж болон бусад холбогдох байгууллагууд хамтран гүйцэтгэнэ.

8.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар гүйцэтгэнэ.

Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилт, тайлан мэдээллийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүнс, хөдөө, аж ахуйн газар болон бусад холбогдох байгууллагууд хамтран нэгтгэж үр дүн, тайланг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

9.2. Аймгийн Засаг даргын Тамгын газар хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн эхний улиралд багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулна.

9.3. Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд 2 жилд нэг удаа хөндлөнгийн хяналт, шинжилгээ үнэлгээ хийлгэж үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна.

-оОо-